



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 452

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.5, 6.6, 6.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн, нийт 12,852,000.00 (арван хоёр сая найман зуун тавин хоёр мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Гүрсоронзон нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, эргэлтийн хөрөнгөд орлогод авах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Акталж данснаас хассан тээврийн хэрэгслийг улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001338

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2021 оны 10
дүгээр сарын 10-ний өдрийн
дугаар тогтоолын хавсралт

**"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж,
данснаас хасах хөрөнгийн жагсаалт**

№	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Тоо хэм жээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын, Хуримтлагдсан элэгдэл дүн (төгрөг)
1	Мицубиши пажеро маркийн, 00-10 ГСА улсын дугаартай суудлын автомашин, арлын дугаар - V464018506	1994/2006	1	7,352,000.00	7,352,000.00
2	Ниссан санни маркийн, 52-00 ӨВА улсын дугаартай суудлын автомашин, арлын дугаар-FB15020791	1999/2008	1	5,500,000.00	5,500,000.00
	ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН		2 (хоёр)		12,852,000.00 (арван хоёр сая найман зуун тавин хоёр мянга)